

Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг удирдсан:

П.Амаржаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн доктор, дэд профессор

Судалгааг гүйцэтгэсэн:

О.Төрболд

Эрдэм шинжилгээний ажилтан

Ч.Батзориг

Эрдэм шинжилгээний ажилтан

Ц.Оюунчимэг

Эрдэм шинжилгээний ажилтан

Судалгааг хянасан:

С.Энхцэцэг

Захирал

АГУУЛГА

ХУРААНГУЙ	4
УДИРТГАЛ	5
Судалгааны ажлын зорилго	6
Судалгааны арга зүй	6
Судалгааны хүрээ	6
НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН АСУУДАЛ	7
1.1 Сэтгэл санааны хохирлын ойлголт	7
1.2 Монгол Улсын эрх зүйн зохицуулалт	9
ХОЁР. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА	12
2.1 Оросын Холбооны Улс	12
2.2 Финланд Улс	14
2.3 Швед Улс	15
2.4 Америкийн Нэгдсэн Улс	18
2.5 Япон Улс	19
2.6 Бельги Улс	21
ДҮГНЭЛТ, САНАЛ	23
НОМ ЗҮЙ	24

ХУРААНГУЙ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн захиалгын дагуу хүний сэтгэл санааны хохирлыг тооцох зарим улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсад хүний сэтгэл санааны хохирлыг тооцох эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны тайлангийн Нэгдүгээр бүлэгт сэтгэл санааны гэм хорын ерөнхий ойлголт ба Монгол Улсын эрх зүйн орчин, Хоёрдугаар бүлэгт бусад орны зохицуулалтыг харьцуулж авч үзлээ.

Тухайлбал, сэтгэл санааны хохирлын талаарх ойлголтын хүрээнд олон улсын чиг хандлага, үзэл баримтлалыг судлахаас гадна Монгол Улсын тухайд сэтгэл санааны хохирлыг хууль зүйн хүрээнд тайлбарлаагүй байх тул дээрх ойлголтыг тодруулах үүднээс бусад улсын хуульд хэрхэн тусгасныг судлав.

Мөн Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болон энэ талаарх эрх зүйн зохицуулалт бий эсэхийг уг судалгаагаар тодруулсан болно.

Бусад улсын зохицуулалтыг харьцуулан судлах хүрээнд Оросын Холбооны Улс /цаашид "ОХУ" гэх/, Америкийн Нэгдсэн Улс /цаашид "АНУ" гэх/, Финланд Улс, Швед Улс, Япон Улс болон Бельги Улсын сэтгэл санааны хохирлын ерөнхий зохицуулалт, нөхөн төлбөрийг тооцох аргачлалыг харьцуулж дүгнэсэн. Үүний хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүллээ.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 14 дэх хэсэгт: “Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” хэмээн заажээ. Үндсэн хуулийн дээрх суурь зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн 8, 9 дүгээр зүйл болон 18, 52 дугаар бүлгүүдэд хуульчлагдсан. Бие махбодын болон эдийн хохирлыг Иргэний болон Эрүүгийн хуулийн хүрээнд хангалттай зохицуулсан байна. Харин эдийн бус хохирлын тухайд түүний арилгах арга замыг зааж өгснөөс бус хохирлын хэмжээг тодорхойлох талаар нарийвчлан тусгаагүй.

Сэтгэл санааны хохирлыг тооцож арилгах заалт байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг шийдвэрлэхгүй орхиж болохгүй юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй” хэмээн заасан байдаг. Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө” гэжээ. Энэ ч үүднээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.” Мөн Пактын 14 дүгээр зүйлийн 6-д “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ.” хэмээн тус тус заасныг үндэслэл болгон шүүх хэргийг шийдвэрлэж болох хэдий ч нарийвчлан зохицуулаагүйгээс үүдэн зөрчигдсөн эрх бүрэн сэргэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Иймд иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн төлөх эрх зүйн орчин, тогтолцоо механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын тухайд Иргэний хууль, Эрүүгийн хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар эд хөрөнгийн хохирлыг бүрэн тооцож байгаа ч эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцож арилгахыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.

Судалгааны ажлын зорилго

Судалгааны ажлын хүрээнд эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, хүний эрхийн хэрэгжилтийг харгалзан Финланд Улс, Швед Улс, ОХУ, АНУ, Бельги Улс болон Япон Улсыг сонгон судалж, жишиг болохуйц туршлага илрүүлэх, мөн дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулах

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчилэх аргуудыг тус тус хэрэглэсэн болно.

Судалгааны хүрээ

“Хүний сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал болон гадаад улсын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлын хүрээнд сонгон авсан гадаад орнуудын эдийн бус гэм хорын эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, эдийн бус гэм хорыг тооцох аргачлал, шалгуур зэрэг зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН АСУУДАЛ

1.1 Сэтгэл санааны хохирлын ойлголт

Иргэний эрх зүй дэх гэм хор түүнийг хэрхэн төлж арилгах арга хэлбэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь сэтгэл санааны гэм хор байдаг.¹ Сэтгэл санааны гэм хор гэдгийг тодорхойлохын тулд юуны өмнө гэм хорын тухай ойлголтыг авч үзэх шаардлагатай. Иргэний хуулийн 497-514 дүгээр зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцааг зохицуулсан байдаг. Хуульд “гэм хор” гэсэн ойлголтыг тодорхойлж өгөөгүй. Гэм хор нь субъектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг.² Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт “хохирол” гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэм хор ба хохирол гэсэн нэр томъёо нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн эрхийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ³ гэж үздэг.

Эдийн бус гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно. Эдийн бус баялагт амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц зэрэг орно. Эдийн бус хувийн эрх гэдэгт оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх, өөрийн нэрийг хэрэглэх эрх зэрэг орно. Эдгээр баялаг, эрхийг эдийн бус гэж тодорхойлох гол шалгуур бол түүнийг бусад этгээдэд дамжуулж болдоггүй, зөвхөн тухайн этгээдэд хамааралтай байдаг онцлогтой юм.⁴

Эд хөрөнгийн бус амины эрхийг хувь хүний оршин буйтай холбоотой иргэний эрхүүд, нийгэмд оршин байхтай холбоотой иргэний эрхүүд гэж ангилж авч үздэг байна. Хувь хүний оршин буйтай холбоотой иргэний эрхүүдэд амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хувийн халдашгүй байдал, эрх чөлөө зэрэг эрхүүд, харин нийгэмд оршин байхтай холбоотой иргэний эрхүүдэд иргэний нэр, хувийн амьдрал, чөлөөтэй зорчих, нэр хүнд, алдар хүнд ажил хэргийн нэр хүндтэй байх эрхүүдийг хамруулдаг байна.⁵

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт⁶ Эд хөрөнгийн бус хохирол гэдэг нь материаллаг бус бүх хохирлыг хэлнэ. Тухайлбал, бие эрхтэний болон сэтгэцийн хохирол, цаашлаад амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна хэмээн тодорхойлсон байна. Харин бусад улсын тухайд Иргэний хуульдаа эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: ОХУ-ын Иргэний хуульд “сэтгэл санааны хохирол гэдэгт иргэний хувийн эдийн бус эрх эсхүл түүнд

¹ Б. Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (УБ, 2011),

² Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр (УБ, 1999), 89 дэх тал.

³ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (УБ, 2007), Адмон хэвлэл, 138 дахь тал.

⁴ Ш.Үнэнтөгс, “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт” Хууль дээдлэх ёс №4, (2007): 51 дэх тал.

⁵ Э. Золзаяа, “Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №4 (2013): 28 дахь тал.

⁶ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/, (2010): 458 дахь тал.

хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна. Сэтгэл санааны хохирол нь гэм буруутай этгээдийн гэм буруугаас үл харгалзан аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол, иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол хуульд заасан бусад тохиолдол”⁷, Филиппин Улсын Иргэний хуульд “сэтгэл санааны хохирол гэдэг нь бие махбодын зовлон, шаналал, айдас, ноцтой түгшүүр, сэтгэл санааны цочрол, нийгмийн доромжлол эдгээртэй төстэй гэмтэл орно”⁸ гэж тус тус заажээ. Эдгээрээс үзвэл сэтгэл санааны хохирол гэдэг нь эд хөрөнгийн хохирол болон эд хөрөнгийн бус хохирлоос үүссэн сэтгэл зүйд бий болсон зовлон шаналал гэж ойлгож болохоор байна.

Эд хөрөнгийн бус амины эрхийн үндсэн шинж чанарууд нь:⁹

1. Эд хөрөнгийн бус амины эрх нь туйлын эрх юм. Өөрөөр хэлбэл тодорхой эрх бүхий этгээдийн эсрэг түүний эд хөрөнгийн бус амины эрхийг зөрчихгүй байх үүрэг бүхий тодорхой бус этгээдүүд байна.
2. Эд хөрөнгийн бус амины эрх нь салшгүй эрх юм. Өөрөөр хэлбэл нэг этгээдээс нөгөөд шилжиж болохгүй.
3. Эд хөрөнгийн агуулгагүй байна, өөрөөр хэлбэл эд хөрөнгийн биш хувийн шинж чанартай байна.
4. Тухайн иргэн эсхүл хуулийн этгээдтэй салшгүй холбоотой байна. Эдгээр зарим эрх нь хүнийг төрснөөр бий болж нас барахад дуусгавар болдог.
5. Тодорхой иргэн, хуулийн этгээдэд байх эд хөрөнгийн бус амины эрхтэй этгээдээс уг баялгийг салгаж үл болох /нэртэй байх, нэр төр, алдар хүнд/.
6. Эдгээр баялаг нь иргэний эрх зүйн хэлцлийн аливаа нэгэн зүйл болохгүй байх. Өөрөөр хэлбэл, амьдрал, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд нь нийгмийн харилцаа хөгжлийн нөхцөлд бараа болж гүйлгээнд орохгүй.

Ингэснээр эд хөрөнгийн бус амины эрх нь эд хөрөнгийн бус шинж чанартай баялгийн эрх бөгөөд эдийн засгийн агуулгагүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдөж, зохицуулагдаж, хамгаалагдаж буй баялаг бөгөөд тэдгээрийг хувь хүн, хуулийн этгээдээс салгаж үл болох эрх юм.¹⁰

Хууль тогтоогч, эрх зүй бүтээгчдийн шийдвэрлэвэл зохих гол асуудал нь гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх ерөнхий болон тусгай дүрэм, хуулиар хамгаалах ашиг сонирхлын хүрээ буюу ямар төрлийн хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг байдаг. Тухайлбал, эд хөрөнгийн хохирлоос гадна эдийн бус хохирол буюу амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд үүссэн сөрөг үр дагавар /өвдөлт, гутрал, ганцаардал гэх мэт

⁷ Л.Дарьсүрэн, “Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал”, Монголын төр, эрх зүй №1 (2014): 59 дэх тал.

⁸ The Civil code of the Philippines, (1949), article 2217.

⁹ Э. Золзаяа, “Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №4 (2013): 31 дэх тал.

¹⁰ Мөн тэнд, 31 дэх тал.

мөнгөөр үнэлж болохгүй алдагдал/, эсхүл цаашдын эдийн засгийн боломжоо алдсан зэрэгтэй холбоотой хохирлыг арилгуулах нь гэм хорын эрх зүйн хүрээнд зохицуулагддаг байна.¹¹ Эдийн бус гэм хорыг дараах байдлаар арилгана. Үүнд:

1. Учирсан материаллаг гэм хорыг арилгах;
2. Сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр гаргуулах;
3. Нэр төр, алдар хүндийг сэргээх.¹²

Нөхөн төлбөр олгох зорилгын хүрээнд хариуцлага ногдуулах нь буруутай этгээдийн үйл ажиллагааны улмаас хохирогчид үүссэн нэмэлт ачаалал, дарамтыг арилгахад чиглэсэн байдаг.¹³

1.2 Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хувьд Эрүүгийн хууль болон Иргэний хуульд эдийн бус хохирлын төрлүүдийг бүрэн бус ч тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Үүнийг дараах байдлаар авч үзэж болно.

- Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан сэтгэл санааны хохирол;
- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль бус үйлдлийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол (эрүүдэн шүүгдсэн, хилсээр ял эдэлсэн, үндэслэлгүйгээр хоригдсон).¹⁴

Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой эдийн бус хохирлыг Иргэний хуулийн 21, 230, 510 дугаар зүйлээр тус тус зохицуулж өгсөн байдаг. Ийнхүү зохицуулахдаа эдийн бус хохирол нь Иргэний эрх зүйн хамгаалалт болох өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болохоос эхлэн түүнийг мөнгөн хэлбэрээр болон бусад аргаар хэрхэн арилгах талаар тусгаж өгсөн. Тухайлбал, Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Иргэний эрхийг эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар хамгаална”, 497 дугаар зүйлд “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заасан байна. Эндээс харахад сэтгэл санаанд учруулсан гэм хорын талаар дурдаагүй байна.

Харин Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол материаллаг хохирлыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэсэн нь материаллаг хохирлын хажуугаар

¹¹ Ж.Оюунтунгалаг, “Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага” Шүүх эрх мэдэл №1, (2019): 96 дахь тал

¹² Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (УБ, 2005), 72 дахь тал.

¹³ Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, (УБ, 2013), 109 дэх тал.

¹⁴ Д.Тамир, “Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал”, Хууль дээдлэх ёс №2 (2010): 50 дахь тал.

материаллаг бус хохирлыг нөхөн төлүүлэх бололцоог бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эдийн бус гэм хорын хэмжээг мэдээ тараасан хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох”-оор зааснаас үзэхэд сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэг үзүүлэлт болж байгаа нь харагдаж байна. Иймд манай хууль тогтоомжид заасны дагуу сэтгэл санааны гэм хорыг эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргаар арилгаж болох үндэслэл байна.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.”, тус зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.” хэмээн заасан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол нэхэмжлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй байна. Энэхүү зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухаанд судлагдах төдий байна. Энэхүү асуудлаар зарим судлаачид дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох ажиллагаа хийгддэггүй;
- Эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх, уг хохирлыг мөнгөөр тооцон үнэлэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй байна.¹⁵

Улсын Дээд шүүхийн “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” 2009 оны 15 дугаар тогтоолын 6.1.2-т “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэм буруутай этгээд эд хөрөнгийн хохирол арилгасан эсэхээс үл хамааран мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах эдийн бус гэм хорын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2.-т зааснаар мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан тодорхойлно.” хэмээн заасан байна. Дээрхээс үзвэл сэтгэл санааны хохирлыг тооцоход дараах шалгуурыг харгалзан үзэхээр байна. Үүнд:

- Мэдээ тараасан арга;
- Тараасан хэрэгсэл;
- Тархсан хүрээ;

¹⁵ Н.Амарзаяа, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт”, Монголын төр, эрх зүй №2 (2014): 9 дэх тал.

- Сэтгэл санаанд учирсан үр дагавар.

Энэхүү тогтоол нь шүүхээс иргэдийн эдийн бус гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх, арилгах, сэргээхтэй холбогдсон харилцааг арга зүйн хувьд шийдвэрлэх боломжийг бүрдүүлж байна гэж болох хэдий ч тус тогтоолын 6.2.4-т “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй.”, “Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгана”¹⁶ гэж тайлбарласан зэргээс харвал Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн зохицуулалт нь “бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ мэдээлэл тараасантай” холбоотой учирсан хохирлыг арилгахтай хамааралтай гэж ойлгогдож байна.

Дээрхээс үзвэл Монгол Улсын эрх зүйн орчинд сэтгэл санааны хохирлыг тодорхойлсон тодорхойлолт байхгүй зөвхөн нэр төр, алдар хүнд хэмээн ойлгогдохоор хуульчилсан байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг илтгэж байна.

¹⁶ Улсын Дээд шүүхийн тогтоол, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”, дугаар 15, 2009 оны 5 дугаар сарын 22.

ХОЁР. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

2.1 Оросын Холбооны Улс

ОХУ-ын Иргэний хуулийн 128 дугаар зүйлд зааснаар иргэний эрх зүйн объектэд эд зүйл, бусад хөрөнгө, ажил үйлчилгээ, мэдээлэл, оюуны үйл ажиллагааны үр дүн, эд хөрөнгийн бус баялгийг нэрлэсэн байна. Иймд ОХУ-ын эрдэмтэн судлаачид нь иргэний эрх зүйн объектыг эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялаг гэж авч үзэж, эд хөрөнгийн бус амины баялагт эдийн засгийн агуулгагүй, хувь этгээдээс салгаж болохгүй, хуулиар зөвшөөрөгдөж, хамгаалдаг эрх, эрх чөлөөг авч үздэг байна.¹⁷ ОХУ-ын Дээд шүүхээс сэтгэл санааны хохирлыг:

- Ойр дотны хүмүүсээ алдсанаас болж учирсан шаналал;
- Идэвхтэй нийгмийн амьдралыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон байдал;
- Ажлаа алдах;
- Гэр бүлийн болоод эрүүл мэндийн байгууллагын нууцыг задлах;
- Нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасантай холбоотой шаналал;
- Ямар нэгэн эрхийг түр хязгаарласан, зөрчсөнтэй холбоотой шаналал;
- Биеийн өвчин зовлон тахир дутуу болсонтой холбоотойгоор гарсан сэтгэлийн шаналал гэх мэтчилэн үргэлжилж болохоор тайлбарлажээ.¹⁸

Тус улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай, Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашигладаг. ОХУ-ын Иргэний хуулийн 150, 151, 152, 1099, 1100, 1101 дүгээр зүйлүүдэд эдийн бус гэм хор болон нөхөн төлбөрийн талаар зохицуулж өгсөн байна. Тухайлбал, 151 дүгээр зүйлд “Хэрэв тухайн иргэнд эд хөрөнгийн бус хохирол учруулсан тохиолдолд шүүхээс гэм буруутай этгээдээр учруулсан эд хөрөнгийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх шийдвэр гаргаж болно.”, 152 дугаар зүйлд “иргэний эсрэг худал хуурмаг мэдээлэл тараах, нэр төр, алдар хүндэд халдсан тохиолдолд тухайн мэдээллийг худал болохыг тогтоолгох болон сэтгэл санааны хохирлыг шаардах эрхтэй”¹⁹ хэмээн зааж өгсөн бол 1099 дүгээр зүйлд ерөнхий сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхэд баримтлах журмыг тусгасан байдаг. Үүнд: Сэтгэл санааны хохирлыг зөвхөн энэхүү хуульд заасны дагуу тодорхойлно. Хуульд заасан тохиолдолд тухайн этгээд нь өөрийн хөрөнгөнд бусдын буруутай үйлдэл, эс үйлдлээс болж учирсан хохирлоос үүссэн сэтгэл санааны хохирлоо нэхэмжлэх эрхтэй. Сэтгэл санааны хохирол нь эд хөрөнгийн хохирлоос хамаарахгүйгээр шийдэгдэнэ.

Харин хуулийн 1100 дугаар зүйлд гэм буруутай эсэхийг харгалзахгүйгээр сэтгэл санааны хохирол шаардаж болох тусгайлсан тохиолдлуудыг дурдсан байна. Жишээ нь, амь нас, эрүүл мэндэд хэн нэгнээс болон онцгой аюулын улмаас хохирол

¹⁷ Э.Золзаяа, “Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №4 (2013): 28 дахь тал.

¹⁸ Ш.Оюунханд, “Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ” Монголын төр, эрх зүй №3 (2013): 36 дахь тал.

¹⁹ The Civil code of the Russian federation, (1994): article 151-152.

учирсан хууль бус аливаа ажиллагаа болох, хууль бусаар аливаа ажиллагаа явуулах, оршин суугаа газраа орхихгүй байхыг хууль бусаар тулгах, захиргааны шийтгэл, албадан хөдөлмөрлүүлэлт, хууль бусаар хорих зэрэг үйл ажиллагаа болсон тохиолдлууд гэх мэт. Мөн бизнесийн нэр хүнд, хүний эрхэм чанар, нэр төр зэргийг гутаасан дордуулсан тохиолдолд цаашлаад хуульд заасан тохиолдлуудад сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх боломжтой байна. Харин 1101 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлыг тооцох, хэмжээ, арга замыг зааж өгсөн байна. Сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөхөөр зохицуулсан бөгөөд хэргийн нөхцөл байдал, хохирогчид учруулсан бие махбодын хохирол, гэм буруугийн хэлбэр, хохирлын нийт хэмжээ зэргээс хамааран шударга, үндэслэлтэй хэмжээгээр шүүхээс тогтоохоор²⁰ тус тус заасан байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн ийм төрлийн хэргийн жишээг дор дурдвал, ОХУ-ын иргэн 1 хиймэл шүд хийлгэхээр очоод эмчийн буруутай үйл ажиллагаанаас болж 5 эрүүл шүдээ авахуулахад хүрсэн байна. Дээрх хэргийн хохирогчид ОХУ-н шүүхээс сэтгэл санааны хохирол болгон 5000 рублийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн байна.²¹

Дээрхээс үзвэл ОХУ-ын зохицуулалт нь илүү ерөнхий байгаа ч гэсэн хамгаалах ёстой эрх ашгаа хамгаалахад сайн зохицуулалт болсон байгаа бөгөөд ихэвчлэн бие махбод болон зарим амины эрхэд учирсан хохирлоос үүдсэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээр зохицуулсан нь харагдаж байна.

Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг дээрх хууль тогтоомжоор зохицуулахаас гадна шүүхийн практикт зарим тохиолдолд А.М.Эрделевскийн хүснэгтийг хэрэглэж байна. Тодруулбал:

$$D=d*f(v)*i*c*(1-f(s))^{22}$$

D- сэтгэл санааны хохирлын дүн

d- сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ

f(v)- гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь $0 < f(v) < 1$ байна

i- хохирогчийн хувийн онцлог, $0 < i < 2$

c- анхаарвал зохих нөхцөл байдал, $0 < c < 2$

f(s)- хохирогчийн гэм буруутай байдал, $0 < f(s) < 1$

Энэ томъёоллоос харахад бодит сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн дээд хэмжээ учирч болохуйц сэтгэл санааны гэм хорын хэмжээнээс дөрөв дахинаас хэтрэхгүй байхаар харагдаж байна. Энэ томъёоллыг хэрэглэхэд гэм хор

²⁰ Н.Баярсүрэн, "Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт", Монголын төр, эрх зүй №2 (2018) 3 дахь тал.

²¹ Ш.Оюунханд, "Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ" Монголын төр, эрх зүй №3 (2013): 37 дахь тал.

²² А.М Эрделевский, *Компенсация морального вреда*, (Москва: 2007), с.241-242.

учруулагчийн гэм буруугийн хэмжээнд дараах үнэлгээг хэрэглэж болно гэж үздэг. Үүнд:

$f(v) = 0.25$ энгийн болгоомжгүй

$f(v) = 0.5$ бүдүүлэг болгоомжгүй

$f(v) = 0.75$ шууд бус санаатай

$f(v) = 1$ шууд санаатай

Мөн гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал нөхөн төлбөрийн хэмжээг бууруулж болох ба хэрэв санаатай гэм хор учруулсан бол үүнийг харгалзан үздэггүй гээд ийм үед дараах томъёоллыг хэрэглэж болно гэжээ:

$$D = d * f(v) * i * c * (1 - f(s)) * p$$

p- гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал

$$0.5 < p < 1$$

гэж томъёолсон байдгийг анхаарах шаардлагатай.²³

Хохирлын нөхөн төлбөрийг тухайн буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс энэхүү нөхөн төлбөрийг олгодог. Нөхөн төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.²⁴

2.2 Финланд Улс

Тус улсын 1974 оны “Гэм хорын хариуцлагын акт”-д хувь хүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн барагдуулах мөн гэмт хэргийн эсвэл хүчирхийллийн улмаас үүссэн зовлон шаналалыг нөхөн барагдуулах тухай заасан байна. Энэ хуулийн 5 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд хувь хүний хохирол гэдэгт шаардлагатай эрүүл мэндийн болон бусад зардлууд, орлогын алдагдал, бие махбодын болон сэтгэл санааны шаналал ба зовлон, эрхтэний ба гоо зүйн түр зуурын болон байнгын гэмтэл зэргийг хамруулах бөгөөд эдгээр нь эрүүл мэндийн эрх зүйн шалгуурын үндсэн дээр тодорхойлогдоно гэж заажээ.²⁵

Зовлон, шаналал буюу сэтгэл санааны хохирол нь хүний үндсэн эрхийн зөрчилд хамаарах ба уг хуулиар хувь хүний эрх чөлөө, амгалан тайван байдал, алдар хүнд ба хувийн амьдрал, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх зэргийг зөрчсөн эрүүгийн гэмт хэрэг мөн хувь хүний халдашгүй байдлыг зориудаар эсвэл хүндрүүлсэн хайхрамжгүй байдлаар зөрчсөн зэргийг авч үздэг байна. Эдгээр нь бодитой сэтгэл санааны хохирол бөгөөд эмпирик тодорхойлолт шаардлагагүй аж. Хохирлыг бүрэн барагдуулах үндсэн зарчмын хүрээнд хохирсон хүний хөндөгдсөн

²³ Ш.Үнэнтөгс, “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт” Хууль дээдлэх ёс №4 (2007): 53 дахь тал.

²⁴ Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 7 дахь тал.

²⁵ Vahingonkorvauslaki, (1974): article 2.

эрх болон эд хөрөнгийг өмнөх байдалд нь сэргээсэн байх ёстой. Энэ зарчим нь зарим стандартчлагдсан нөхөн олговор, гэмт үйлдэлтэй холбоотой төрөөс олгох нөхөн олговор, тодорхой гэмт хэрэгт нийт олгогдох нөхөн төлбөр зэрэг төрөлтэй бөгөөд шүүгч нөхцөл байдлыг харгалзан үзэж үнэнч шударгаар тодорхойлно.²⁶

2004 онд Финланд Улсын Хууль зүйн яам (Oikeusministeriö) шүүхийн практикт хяналт, шинжилгээ хийж “Гэм хорын хариуцлагын акт”-д заасан зовлон, шаналал ба материаллаг бус хохирлын хэмжээг тодорхойлох, боловсронгуй болгох “Хувь хүний хохирлын Зөвлөх комисс”-ыг байгуулсан байна. Комиссын зөвлөмжийн 3 дугаар бүлэгт зовлон, шаналал гэдгийг хүний үндсэн эрхийг зөрчсөнөөс үүдсэн бодитой сэтгэл санааны нөхцөл байдлын үр дагавар гэж тодорхойлсон байна.

Тус комиссын зөвлөмжид зарим эд хөрөнгийн бус хохирлыг барагдуулахад олгох нөхөн олговрын доод болон дээд хэмжээг тодорхойлсон байна. Тухайлбал, хүний халдашгүй байдалд халдсан бол 200-500 еврог, урт хугацааны бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд эсвэл нэг удаагийн бэлгийн мөлжлөгт өртсөн бага насны хүүхдэд 10,000-30,000 хүртэл еврог сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт олгох тухай дурдсан байна. Мөн тус зөвлөмжийн 4 дүгээр бүлэгт дотны хүн нь нас барсанаас үүдсэн сэтгэл санааны хохиролд зориулсан нөхөн олговрыг дараах байдлаар тусгажээ. Үүнд: хүүхдээ алдсан бол 2,000-11,000 евро, эцэг эхээ алдсан бол 2,000-15,000 евро, төрсөн ах дүүгээ алдсан бол 2,000-8,000 евро, нөхөр эсвэл эхнэрээ алдсан бол 3,000-11,000 евро тус тус олгоно гэжээ.²⁷

Финланд Улсын хувьд мөн хувь хүний хохирлын хариуцлагыг зохицуулсан салбарын хуулиуд байдаг бөгөөд нийгэм хамгааллын хүчтэй тогтолцоотой улсын хувьд зарим эмзэг салбарт тухайлбал, тээврийн хэрэгслийн хэрэглээ, эмнэлэг, эрүүл мэндийн зөрчлийн хариуцлагаас үүдсэн нөхөн олговрыг даатгалаас олгодог байна.

Харин “Эрүүгийн гэмт хэргийн хохирлыг барагдуулах акт” -ын 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд “гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын нөхөн олговрыг улсын сангаас олгоно” хэмээн заажээ. Мөн энэ хуулиар улсын сангаас олгох нөхөн олговрын дээд хэмжээг тодорхойлсон байх бөгөөд гэмт хэргийн улмаас үүссэн шаналгаа, зовлон болон бусад түр зуурын хохиролд 12,000 евро, бэлгийн чиг хандлага, хувь хүний эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн улмаас үүссэн зовлонд 9,400 евро энэ тохиолдолд хохирогч хүүхэд бол 16,000 евро зэргийг олгодог. Ямар ч тохиолдолд хувь хүний хохирол болон сэтгэл санааны зовлонд зориулсан нөхөн олговор 61,000 еврогоос хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.²⁸

2.3 Швед Улс

Тус улсад гэмт хэргийн хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо гурван үндсэн аргаар нөхөн төлүүлэх боломжтой. Нэгдүгээрт, хохирогч шүүхийн тодорхойлсноор Шведийн “Гэм хорын хариуцлагын акт”-ын дагуу гэмт этгээдээс

²⁶ Carlo I. Cremonesi, Ville Pönkä, Compensation for personal injuries in Finland, (2015), p.3.

²⁷ Recommendations of the Personal Injury Advisory Committee.

<https://oikeusministerio.fi/hanke?tunnus=OM035:00/2006>

²⁸ Riksovetshankolaki, (1973): article 1.

хохирлыг нөхөн төлүүлж болно.²⁹ Хоёрдугаарт, хохирогч нь даатгалд хамрагдсан тохиолдолд даатгалын компаниас хохирлоо гаргуулж болно. Гуравдугаарт, Шведийн гэмт хэргийн хохирогчийн “Хохирол барагдуулах, дэмжих газар” (Brottsoffermyndigheten)-аар дамжуулан хохирогч хохирлоо Засгийн газрын сангаас төлүүлж болдог байна.³⁰

Швед Улсад үүрэг хариуцлага болон нөхөн төлбөрийг ерөнхийд нь 1972 оны “Гэм хорын хариуцлагын акт”-аар зохицуулдаг ба хохирлыг барагдуулах асуудлыг энэ хуулийн 5 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тусгасан. Эдгээр зохицуулалтууд нь хохирогчийн нөхөн төлбөрийг бүрэн барагдуулах баталгааг уг хуулийн зарчмын дагуу хангахыг зорьсон.³¹ Үүнээс гадна зарим салбарын тодорхой төрлийн хохирлыг тусгай хууль журмаар зохицуулдаг. Жишээлбэл: Байгаль орчны тухай хуулийн 32 дугаар бүлэг, “Зам тээврийн хохирлын акт”, “Өвчтний хохирлын акт”, “Үйлдвэрлэлийн хариуцлагын акт” гэх мэт. Гэхдээ хохирлын нөхөн олговрыг үнэлэхдээ “Гэм хорын хариуцлагын акт”-ын зүйл заалтыг эдгээр салбарт ашигладаг.

Гэм хорын хариуцлагын акт нь хувь хүний хохирол нөхөн төлөгдсөн байх ёстой гэсэн зарчмыг удирдлага болгодог. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн зориудаар эсвэл хайхрамжгүй байдлаар хувь хүнд эсвэл эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг барагдуулах ёстой гэж уг хуулийн 2.1 дүгээр зүйлд тодорхойлсон байна. Уг хуулиар хайхрамжгүй байдлаар эд хөрөнгөд хохирол учруулсан үйлдлийн хариуцлага болон зориудаар хохирол учруулсан үйлдэлд оноох хариуцлагыг ялган зохицуулсан бөгөөд хайхрамжгүй байдлаас үүдсэн тухайн хохирлыг хариуцагч барагдуулах бол зориудаар буюу шууд санаатай үйлдсэнээс үүссэн бүх хохирлыг хариуцагч барагдуулахаар тус тус заасан байна.

Хайхрамжгүй байдлыг шалгахдаа хэрэв зохицуулсан журам байхгүй бол шүүгч асуулгаар шалгах ёстой. Швед Улсын хувьд үүнийг шалгахдаа “Hand Test”-ийг ашигладаг ба доорх шинжүүдийг тодруулдаг. Үүнд:

1. Хохирол учрах эрсдэл;
2. Боломжит хохирлын хэмжээ эсвэл ноцтой байдал;
3. Хариуцагчийн энэхүү эрсдэлээс сэргийлж болох байсан зардал;
4. Хариуцагчийн хохирлыг урьдчилж харах боломж.

Эдгээр хүчин зүйлсийг үйлдэл хайхрамжгүй байсан эсэхийг үнэлэхийн тулд өөр хооронд нь харьцуулдаг байна.

Энэ хуулийн 5 дугаар бүлэгт хохирлын төрлийг тодорхойлсон бөгөөд хувь хүний хохиролд эд хөрөнгийн бус буюу зовлон, шаналал зэргийг тооцно гэж заасан байна. Тухайлбал, энэ бүлгийн 6 дугаар зүйлд доорх шинж байдал ажиглагдсаныг хохирол гэж үзэхээр заажээ. Үүнд:

- тухайн үйлдэл нь доромжилсон эсвэл гутаасан агуулгатай;
- амь нас, эрүүл мэндэд нөлөөлөхүйц ноцтой айдас төрүүлсэн;
- хөгжлийн бэрхшээлтэй хүнийг доромжилсон;
- хамаарал эсхүл итгэлийг ашиглан хүчирхийлсэн;

²⁹ Skadeståndslagen, (1972).

³⁰ Mannelqvist, R., Compensation for victims in public legislation and as a civil right. *Scandinavian Studies in Law*, 50, 423-434, (2007), p.425.

³¹ Skadeståndslagen, (1972): chapter 5.

- олон нийтийн тав тух алдуулсан.

Швед Улсын хувьд хувь хүний хохирлын нөхөн төлбөрийг барагдуулахад энгийн хуулийн процессоор шийдвэрлэснээс илүү уян хатан, оновчтой нөхөн төлбөрийн системтэй бөгөөд энэ нь хуулийн салбарт тулгамдсан маш олон асуудлыг шийдэж чаддаг. Энэ нь тухайн тохиолдолд зориулсан даатгал бөгөөд ерөнхийдөө дараах 3 төрлийн даатгал байна.³² Үүнд:

- Хөдөлмөрийн ослын аюулгүй байдлын даатгал;
- Өвчтний даатгал;
- Эм бэлдмэлийн даатгал.

Тодруулбал: Аюулгүй байдлын даатгалаас хөдөлмөрийн ослын хохирогч нь гэм хорын актын хэм хэмжээний дагуу орлогын алдагдалд зориулсан нөхөн төлбөр авах бөгөөд мөн нэмэлтээр сэтгэл санааны хохиролд зориулсан нөхөн төлбөр авдаг байна. Өвчтний даатгалаас тухайн өвчтөн эмчилгээнээс үүдэлтэй зовлон, шаналалын хохирлын нөхөн төлбөр авдаг. Харин эм бэлдмэлийн даатгалаас хохирогч эм бэлдмэлийн нөлөөгөөр ноцтой хохирсон бол нөхөн төлбөр авах ба хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг гэм хорын актын зүйл заалтын дагуу тооцдог.³³

Мөн эд хөрөнгийн бус хохиролын нөхөн төлбөрийн асуудлыг Швед Улсын Хууль зүйн сайдын томилсон комисс судлан зарим зарчмыг тодорхойлсон байна. Комиссын зүгээс энэ төрлийн хохирлыг үнэлэхдээ дур зоргоор бус тохирсон шалгуурт үндэслэсэн байх нь чухал гэж үзсэн. Шалгуурт хохирлын нөлөөлсөн хугацаа, шаналалын хурцадмал байдал, болон бие махбодын гэмтлийн зэрэг зэргийг хамруулсан байна. Гэм хорын хариуцлагын актын 5.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу энэ төрлийн хохирлын нөхөн төлбөрийн систем доорх зүйлсээс бүрдэж байна. Үүнд:

Зовлон, шаналал: Энэ төрлийн хохирлын нөхөн төлбөр нь сэтгэл санааны шаналал болон өвчнөөс үүдсэн бие махбодын өвдөлтийн цочмог үеийн хугацаанд зориулагддаг. Нөхөн төлбөрийн хэмжээг бодитой тоон шалгуурт суурилсан стандарчлагдсан схемийн³⁴ дагуу тооцдог. Тухайлбал, нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо эмнэлэгт эмчлүүлсэн хугацаа, эмчилгээний үеийн шаналал, тусгаарлагдсан байдал зэргийг харгалзан үздэг. Нөхөн төлбөр хамгийн ихдээ 1998 онд 100,000 крон байсан байна.

Байнгын хохирол: Бие махбодын болон сэтгэл зүйн хувьд учирсан байнгын хохиролд нөхөн төлбөр төлөх ба хохирлыг тооцоход нас болон эрүүл мэндийн хохирлын зэргийг авч үзнэ. Энэ төрлийн хохирлын хэмжээ хамгийн ихдээ 800,000 крон байсан байна.

Бусад: Эдийн бус хохирлын бусад онцгой тохиолдолд хохирлыг бүрэн барагдуулах зорилгоор нэмэлт нөхөн төлбөр олгодог.

Швед Улсад нэр хүнд нь хохирсон хүмүүс “Хэвлэл мэдээллийн гомдлыг шийдвэрлэх байгууллага” эсхүл “Шведийн өргөн нэвтрүүлгийн газар”-т хандахаас гадна шүүхэд хандаж шийдвэрлүүлж болдог байна. Жишээлбэл, 2016 оны 12 дугаар сард Стокольм хотын шүүгч Шведийн Экспрессэн сонины ахлах редактор Отто

³² Erland Strömbäck, Personal Injury Compensation in Sweden, 2000, p.434.

³³ Erland Strömbäck, Personal Injury Compensation in Sweden, 2000, p.435.

³⁴ Схем нь Замийн хөдөлгөөний ослын зөвлөлөөс батлагдсан бөгөөд Швед Улсын дээд шүүх хэрэглэхийг зөвшөөрсөн (NJA 1972 p.81).

Сёоберг гэгчийг Шведийн жүжигчин Майкл Персбрандтыг гүтгэсэн гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө шийтгэсэн байна. Жилийн өмнө Экспрессэн сонин жүжигчнийг архины хордлогын улмаас Уппсалагийн эмнэлэгт хүргэгдсэн талаарх мэдээллийг нийтэлжээ. Жүжигчин мэдээллийг үндэслэлгүй хэмээн үгүйсгэсэн бөгөөд үүний дараа Экспрессэн сониноос нийтлэл эх сурвалжаас ташаа мэдээлэгдсэн мэдээ хэмээгээд алдаа гаргасанаа хүлээн зөвшөөрч, уучлалт гуйсан байна.

Жүжигчин сонины редакцийг өөрийг нь гүтгэсэн хэмээн шүүхэд өгч сэтгэл санааны хохирлын төлбөрт 500,000 крон нэхэмжилсэн байна. Прокурор Сёоберг болон сонины эсрэг төлбөрийг гаргуулахаар шүүхэд шилжүүлсэн байна. Шүүх хурал дээр Сёоберг сонины байр суурьт халтай ноцтой алдаа хийснээ хүлээн зөвшөөрсөн ба Экспрессэн сонины өмгөөлөгчид хэлэхдээ жүжигчнийг архины хамаарлаас салахыг хүсч байсныг олон нийт мэддэг байсан тул түүний нэр хүнд хэдийгээр эмнэлэгт хүргэгдсэн гэх мэдээлэл худал байлаа ч энэ нийтлэлээс болж хохироогүй гэв. Есөн гишүүнтэй шүүх бүрэлдэхүүн Сёобергийг хүндрүүлсэн гүтгэлэг үйлдээгүй гэж үзсэн ч түүнийг гүтгэлэгийн хэм хэмжээг зөрчсөн гэж үзжээ. Ингээд Стокольмын дүүргийн шүүх түүнд 80 өдрийн турш өдөр бүр жүжигчинд 1000 крон (нийтдээ 80,000 крон) мөн жүжигчний сэтгэл санааны хохиролд зориулж 75,000 крон төлөх шийтгэл оногдуулсан байна.³⁵

2.4 Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын хувьд 1982 онд баталсан Гэмт хэргийн үйлдлийн Нэгдмэл хохирогчийн тухай хуулиар сэтгэл санааны хохирол, нөлөөллийн талаар мэдээлэл өгөх эрхийг нь баталгаажуулсан.³⁶ Тухайлбал: 2017 оны 4 дүгээр сард Аова мужийн каунтигийн тангарагтны шүүхээс (Huiitt v. Iowa Clinic) хорт хавдарын оноштой гэсэн өвчтөнд мэс засал хийсэн хэрэгт тухайн хохирогч хорт хавдаргүй байсан нь тогтоогдож тэрээр сэтгэл санааны хүнд хохирол хүлээсэн гэх нэхэмжлэлийг Аова мужийн каунтигийн тангарагтны шүүхээс хангахаар шийдвэрлэн хохирогчид 12.5 сая ам.долларын нөхөн төлбөрийг эмнэлэг төлөх болсон байна.³⁷

Холбооны болон мужийн хэмжээнд Холбооны гэмт хэрэг үйлдсэн этгээдээс төлсөн торгуулийг хохирогчдод нөхөн төлбөр олгох сангийн хуримтлал³⁸ үүсгэх ажлыг 1960 оноос эхлүүлсэн бөгөөд тус улсын 50 мужид “Мужийн Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай” Холбооны Засгийн хөтөлбөр (CVC) /дунджаар 25000 ам.долларын нөхөн төлбөр/ хэрэгжүүлдэг.³⁹

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас санхүүгийн алдагдал хүлээсэн, мөн бие махбод болон сэтгэл санааны цочролд орсон хохирогч нь эрүүл мэндийн болон зөвлөгөө авах үйчилгээнээс үүдэн гарах аливаа санхүүгийн зардлаа хэрхэн төлөх,

³⁵ Claus Granath, “Juryn faller Sjöberg för förtal”, 2006, <https://www.sydsvenskan.se/2006-11-24/juryn-faller-sjoberg-for-fortal>.

³⁶ Judith Platania Garrett L. Berman, The Moderating Effect of Judge's Instructions on Victim Impact Testimony in Capital Cases,

³⁷ <https://www.injuryclaimcoach.com/pain-and-suffering-reimbursement.html>

³⁸ The Handbook on Justice for Victims UNODCCP

³⁹ АНУ-ын Холбооны Засгийн Газрын албан цахим хуудас, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, <https://www.benefits.gov/benefit/4416>; <http://nacvcb.org/index.asp?sid=5>

гэнэтийн үхэл болон хөгжлийн бэрхшээлээс болж алдагдсан боломж болох орлогоо хэрхэн нөхөх талаар санаа зовохгүй байж хүчирхийлэл, доромжлолоос буцаж хэвийн байдалдаа эргэн орох явдал нь маш хэцүү асуудал юм. Тус хөтөлбөр нь дээрх нөхцөл байдлаас гарахад тус хөтөлбөр туслах зорилготой бөгөөд муж бүрт хэрэгжүүлдэг. Мөн засгийн газрын хөтөлбөрийг хууль бус аргаар ашиглах, завшихаас сэргийлсэн Зөвлөмжийг⁴⁰ баримталж ажиллахыг мөрдлөг болгодог.

Мөн 11 муж нөхөн төлбөрийн дээд хэмжээний тухай хууль гаргасан (энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх), зарим муж 300 мянгаас 5 сая хүртэл ам.доллар гэж тогтоосон, 13 муж Улсын сан (Treasury), эсхүл Адил тэгш шударга ёсны эвслээс тогтоосон хувь хэмжээг удирдлага болгодог ажээ.

Мөн АНУ-ын Дээд шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг 9 дахин ихэсгэснээс хэтэрч болохгүй гэж тусгайлан шийдвэр гаргасан нь орон даяар хэрэгжих жишээтэй.⁴¹

Тус улсад гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол хүлээсэн хохирогчдод сэтгэл зүйн нөхөн сэргээлт эмчилгээг үзүүлдэг бөгөөд АНУ-ын Сэтгэл Судлалын Холбооноос /APA/ Сэтгэл санааны хямралд орсон үеийн эмчилгээний үед баримтлах Зөвлөмж⁴², мөн Гэмтлийн дараах стрессийн эмгэг⁴³ (PTSD)-ийн⁴⁴ гурван үндсэн (APA DSM-IV-TR) зэрэглэлийг хэрхэн тодорхойлох тухай албан ёсны Зөвлөмжийг сэтгэл зүйн хохирлыг тогтоох холбогдох эрх бүхий мэргэжлийн лиценз бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд үйл ажиллагаандаа баримтлахад зориулан баталсан. Мөн тус байгууллагаас 2002 оны 8 дугаар сарын 21-ний өдөр "Сэтгэл зүйчийн ёс зүйн зарчим, үйл ажиллагааны дүрэм"-ийг⁴⁵ баталсан.

2.5 Япон Улс

Япон Улсын Иргэний хуулийн 709-724 дүгээр зүйл гэм хорын талаар зохицуулж өгсөн. Тухайлбал, 709 дүгээр зүйлд "Санаатай буюу болгоомжгүй үйлдлээр бусдын эрх ашиг, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн этгээд үүний улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх хариуцлагыг хүлээнэ.", 711 дүгээр зүйлд "Бусдын амь насанд хохирол учруулсан этгээд хохирогчийн эцэг эх, эхнэр нөхөр, болон үр хүүхдэд эд хөрөнгийн хохирол учруулаагүй байсан ч хохирлыг нөхөн төлнө.", 722 дугаар зүйлд "Гэм хор учруулснаас үүссэн хохирлыг нөхөн төлөхөд тус хуулийн 417 дугаар зүйлийг⁴⁶ нийцүүлэн хэрэглэнэ.", 723 дугаар зүйлд "Бусдын нэр

⁴⁰ United States Department of Justice, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, <https://www.justice.gov/usao/page/file/915836/download>.

⁴¹ Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 12-13 дахь тал.

⁴² The American Psychological Association, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, <https://www.apa.org/depression-guideline/appendices.pdf>

⁴³ PTSD буюу Гэмтлийн дараах стрессийн эмгэг (монг. орч) <https://www.slideshare.net/azora14/11-12687528>

⁴⁴ John P. Wilson, PTSD and Complex PTSD Symptoms, Syndromes, and Diagnoses. Сүүлд үзсэн огноо: 2019-09-16 <https://www.guilford.com/excerpts/wilson5.pdf?t>.

⁴⁵ The American Psychological Association, Сүүлд үзсэн огноо 2019-09-16 <https://www.apa.org/ethics/code/ethics-code-2017.pdf>

⁴⁶ Япон Улсын Иргэний хууль, 417 дугаар зүйл "Талууд өөрөөр тохиролцоогүй бол хохирлыг мөнгөөр үнэлж тогтооно"

төр, алдар хүнд гэм хор учруулсан этгээдэд хохирогчийн нэхэмжлэлийн дагуу шүүх хохирлыг нөхөн төлүүлэхийн хамт, нэр төр, алдар хүндийг сэргээхэд шаардлагатай арга хэмжээг авахыг тушааж болно.”⁴⁷ гэж тус тус заажээ.

Шүүхээс хохирлыг тооцохдоо хохирогчийн гэм буруутай эсэх, түүний сэтгэцийн эмзэг байдал, хууч өвчин зэргийг харгалзан үзэх нөхцөл байдалд авч үздэг. ⁴⁸ Жишээ нь: 2019 оны 06 дугаар сард Кумамотогийн анхан шатны шүүхэд 561-н нэхэмжлэгчид Ieprosy буюу Хансений өвчтэй гэх үндэслэлээр Засгийн газраас тусгаарлах бодлого хэрэгжүүлсний улмаас өвчтөнүүдийн гэр бүлийн гишүүд нь нийгмээс тусгаарлагдан ялгаварлан гадуурхагдан эдийн бус хохирол болон бусад хохирол учирсан тул Засгийн газар тэднээс уучлал гуйх, гэр бүлийн гишүүн бүрт 5 сая иений нөхөн төлбөр төлөхийг нэхэмжилсэн. Шүүхээс анх удаа өвчтөний гэр бүлийн гишүүнд Засгийн газраас нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн.⁴⁹ Мөн Нагояо дүүргийн шүүхээс 72 настай хэвлэн нийтлэл бичигч иргэний NHK түүний нийтлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр нь түүнд сэтгэл санааны дарамт учруулсан гэх үндэслэлээр нэхэмжилсэн 1.41 сая иений хэргийг хэрэгсэхгүй болгосон⁵⁰ зэрэг тохиолдлууд гарч байжээ.

Тус Улсын хуулиар хохирогч хохирол хүлээсэн гэж үзснээс хойш гурван жилийн дотор шүүхэд хандах эрхтэй бөгөөд нөхөн төлбөрийн хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байдаг.⁵¹

Япон Улс нь цөмийн эрчим хүч үйлдвэрлэлтээр АНУ, Франц улсын дараа жагсдаг. Энэ ч үүднээс боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд цөмийн хор хохирлын нөхөн төлбөрт зориулсан хураамжийг цөмийн талбар буюу онгоц бүрт 120 тэрбум иен байхаар тооцдог ба гадаад улсын зүгээс цөмийн хөлөг онгоц ирэх бол нэг бүрт нь 36 тэрбум иен нөхөн төлбөрт байршуулахыг шаарддаг байна. Нөхөн төлбөрт зориулсан хураамжаа Хууль зүйн асуудал хариуцсан товчоо буюу Тойргийн хууль зүйн асуудал хариуцсан товчоонд шилжүүлж, Яамны зөвшөөрөлтэйгээр хохирол учирсан талаар гомдол гаргасан этгээдэд олгоно. Нөхөн төлбөр олгох журмыг⁵² Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам болон Хууль зүйн яам хамтарч гаргадаг онцлогтой.

⁴⁷ Япон Улсын Иргэний хууль, (1896), орч. Б.Урангоо, 180-181 дэх тал.

⁴⁸ The Global Class Actions Exchange, Stanford Law School, Сүүлд үзсэн огноо: 2019-09-17, http://globalclassactions.stanford.edu/sites/default/files/documents/Japan_Reevaluating_Role_of_Tort_Liability_System_in_Japan.pdf

⁴⁹ Japan govt ordered to Pay Damages to Relatives of Ex- Leprosy Patients, Сүүлд үзсэн огноо: 2019-09-07, <https://www.nippon.com/en/news/yjj2019062800920/japan-govt-ordered-to-pay-damages-to-relatives-of-ex-leprosy-patients.html>.

⁵⁰ Japan today “Court rules against man who sued NHK for using too many loan words” article, Сүүлд үзсэн огноо: 2019-09-18, <https://japantoday.com/category/national/court-rules-against-man-who-sued-nhk-for-using-too-many-loan-words>.

⁵¹ The Global Class Actions Exchange, Stanford Law School, Сүүлд үзсэн огноо: 2019-09-17, http://globalclassactions.stanford.edu/sites/default/files/documents/Japan_Reevaluating_Role_of_Tort_Liability_System_in_Japan.pdf

⁵² 原子力損害の賠償に関する法律 /Цөмийн хохирлын нөхөн төлбөр олгох журам/, https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=336AC0000000147

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд Цөмийн хохиролтой холбоотой нөхөн төлбөрийн асуудал эрхэлсэн Маргаан таслах хороо ажиллахаар тус тус хуульчилжээ. Энэ хуультай холбогдуулан Ажлын байран дээр ослын даатгалын тухай хуульд (the Insurance Act for the Compensation of Work Accidents (Act No. 50 of 1947)) нийцүүлэн асуудлыг нарийвчлан зохицуулжээ.⁵³

2.6 Бельги Улс

Бельги Улсад гэмт хэргийн хохиролд сэтгэл санааны хохирол болон гэмт хэргээс үүдсэн сэтгэл санааны үр дагаврыг тооцдог бөгөөд сэтгэл санааны үр дагавар нь дотны хүнээ алдах, айдас, жихүүдэс мэдрэх зэргээс үүснэ. Хохирогч гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг батлах нотлох баримтыг гаргах ёстой бөгөөд ингэснээр хууль сахиулагчид хохирлыг тодорхойлоход дөхөм болдог. Тухайлбал, эрүүл мэндийн шинжилгээний бичиг, шинжилгээний болон эмчилгээний төлбөр, нэхэмжлэл гэх мэтийг үрэгдүүлэлгүй хадгалах ёстой.⁵⁴

Тус улсад эдийн бус хохирлыг эрүү, иргэний журмаар буюу бие даасан оролцогчийн стастустайгаар нэхэмжлэх боломжтой байдаг. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно гэсэн үг. Гэхдээ энэ нь зөвхөн хохирогчийн хүсэлтээр хэрэгжих ба шүүгч өөрийн санаачилгаар ажиллагаа явуулах эрхгүй. Харин иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилсэн тохиолдолд хэрэв эрүүгийн процесс дуусаагүй байгаа тохиолдолд иргэний шүүх хэргийг шийдвэрлэхийг түр хүлээдэг. Хэрэв эрүүгийн хэргийг шүүхээс хэрэгсэхгүй болгосон тохиолдолд иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэх боломж тэр хэмжээгээр хумигддаг. Хохирогч нийтийн сангаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно. Гэхдээ тухайн нөхөн төлбөрийг эрүүгийн хэргийн улмаас бие махбодод нь ямар нэгэн гэмтэл учирсан байгаа тохиолдолд л өгөх боломжтой байдаг.

Жишээ нь, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эдийн бус хохирлыг дараах хэлбэрээр нөхөн төлүүлж байна. Үүнд:

- Эмнэлэгт хэвтэхэд нэг өдрийн 31 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсаны нэг өдрийн 25 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 75 хувь алдсаны нэг өдрийн 19 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсаны нэг өдрийн 13 евро ;
- Нэмэлт өвдөлт, шаналал зовиурт мөн нөхөн төлбөр өгнө.

Харин хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тохиолдолд хохирогчийг насны байдлаар нь ангилан үзэж нөхөн төлбөр дараах хэмжээгээр олгож байна:

- 10 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 3300 евро;
- 35 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 2425 евро;

⁵³ Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 14 дэх тал.

⁵⁴ Холбооны хууль зүйн төрийн үйлчилгээ, Хохирогчийн гарын авлага, (2016) 18 дахь тал.
<https://justice.belgium.be/sites/default/files/vous-etes-victime-2016-en-web.pdf> .pdf

- 64 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 1410 евро;

Дээр дурдсан тоо хэмжээ хөдөлшгүй зүйл биш бөгөөд шүүгчийн үнэлэмжээр өөрөөр тогтоогдож болдог байна. Бусад эдийн бус хохирлын тухайд дараахь хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байдаг. Тухайлбал,

Гоо сайхны хохиролд 1-7 хүртэлх доорх түвшингээр үнэлж байна:

- 1-р түвшин 250-750 евро;
- 4-р түвшин 2250-8700 евро;
- 5-р түвшин 8700 евро ба түүнээс дээш;
- 7-р түвшин 24800 евро ба түүнээс дээш.

Жишээ нь, тус улсад гэмт хэргийн улмаас нүүрэндээ эдгэшгүй сорви авсан 16 настай хүүхдэд 18600 еврогийн нөхөн төлбөрийг шүүхээс олгосон байна. Түүнчлэн амьдралаас таашаал авах боломжоо алдсаны хохирол, бэлгийн харилцааны хэм алдагдсаны хохирол, сэтгэл санааны тайван бус байдалд оруулсны хохирол зэргийг эдийн бус гэм хорын хэлбэрээр тооцож барагдуулсан байна. Бельги Улсад хохирогчийн ар гэрийнхний сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоо бүрджээ. Жишээ нь:

- Эхнэр/нөхрөө алдсан бол 10000 евро;
- Эцэг эхээ алдсан бол хүн тус бүрт 17500 евро;
- Хүүхдээ алдсан бол 10000 евро.

Бельги Улсад хүнд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тусгай бүтцийг 1985 оны Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль /Victims Compensation Act 1985/-аар бий болгосон. Энэ хуулийн зорилго нь тухайн хохирогчид бүрэн хэмжээгээр нөхөн төлбөр олгохоосоо илүүтэй эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх ажиллагаанаас хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй, эсвэл бусад хэлбэрийн нөхөн төлбөр, жишээ нь тэтгэвэр тэтгэмж, даатгалын төлбөр гэх мэтийг олж авах боломжгүй хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн.⁵⁵

⁵⁵ Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 8-9 дэх тал.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Бусад улсын практикаас харвал гэмт хэргийн улмаас хохирсон хүний санаа сэтгэл, бие эрхтний эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлж арилгах эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль, Гэм хорын хариуцлагын тухай акт, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулж байна. Эдгээр зохицуулалтад нийтлэг байдлаар тодорхой төрлийн үйлдлийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлэн дээд болон доод хэмжээг тусгаж өгч тэр хүрээнд шүүх нотлох баримт, нөхцөл байдлыг үнэлэн нөхөн төлбөрийг ногдуулж байгаа нь харагдаж байна. Мөн хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүднээс Засгийн газар нь нөхөн төлбөр олгох сан байгуулж түүндээ хуримтлал бий болгож байгаа сайн жишиг байна.

Монгол Улсын тухайд Иргэний хууль болон Улсын дээд шүүхийн тогтоолоор эдийн бус гэм хор, болон сэтгэл санааны хохирлыг тооцох талаар зохицуулсан хэдий ч сэтгэл санааны хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүндтэй холбон тайлбарласан, хохирлыг тооцох шалгуур нь тодорхой бус зэрэг дутагдлууд байна. Иймд эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг арилгах дэлгэрэнгүй зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох, шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримтлах эдийн бус хохирлын хэмжээг тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх шаардлагатай байна.

Санал

Судалгаагаар авч үзсэн асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.
Үүнд:

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, шалгуур, хэмжээг тогтоох аргачлал, журам заавар боловсруулж мөрдүүлэх;
- Сэтгэл санааны хохирлын талаарх ойлголтыг хуулийн хүрээнд тодорхойлох;
- Сэтгэл санааны хохирлыг нотлох нотолгооны хэрэгслийг процессын хуулиудад тусгаж өгөх. Тухайлбал, ойр дотны хүмүүсээс хохирогчийн сэтгэл санааны байдлын талаарх мэдүүлэг авах гэх мэт;
- Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараах шалгуурыг харгалзан үзэх талаар эрх зүйн хэм хэмжээний актад тусгаж өгөх. Үүнд: гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ, хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ хэмжээ, бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ шинж чанар, шударга ёсны шаардлага зэрэг;
- Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан иргэдэд Засгийн газрын сангаас нөхөн төлбөр олгох эрх зүйн боломжийг нээж өгч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, Хууль, тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, /1992/.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, /1946/.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, /1966/.
- Иргэний хууль, /2002/.
- Эрүүгийн хууль, /2015/.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, /2002/.
- Улсын Дээд шүүхийн тогтоол, дугаар 15, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай", 2009 оны 5 дугаар сарын 22-н
- Япон Улсын Иргэний хууль
- The Civil code of the Russian federation, /1994/.
- Rikosvahinkolaki, /1973/.
- Skadeståndslagen, /1972/.
- The Civil code of the Philippines, /1949/.
- Vahingonkorvauslaki, /1974/.
- Victims Compensation Act, /1985/.

Ном, өгүүлэл, нийтэл:

- Н.Амарзаяа, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт", Монголын төр, эрх зүй №2 (2014):
- Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (УБ, 2005),
- Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (УБ, 2011),
- Н.Баярсүрэн, "Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт", Монголын төр, эрх зүй №2 (2018)
- Л.Дарьсүрэн, "Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал", Монголын төр, эрх зүй №1 (2014):
- Э.Золзаяа, "Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт", Монголын төр, эрх зүй №4 (2013):
- Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр (УБ, 1999),
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (УБ, 2007), Адмон хэвлэл,
- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/, (2010):
- Д.Тамир, "Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал", Хууль дээдлэх ёс №2 (2010):
- Ш.Оюунханд, "Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ" Монголын төр, эрх зүй №3 (2013):
- Ж.Оюунтунгалаг, "Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага" Шүүх эрх мэдэл №1, (2019):
- Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, (УБ, 2013),
- Ш.Үнэнтөгс, "Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт"

- Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013):

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл

- А.М Эрделевский, *Компенсация морального вреда*, (Москва: 2007),
- Carlo I. Cremonesi, Ville Pönkä, *Compensation for personal injuries in Finland*, (2015),
- Mannelqvist, R., *Compensation for victims in public legislation and as a civil right. Scandinavian Studies in Law*, 50, 423-434, (2007),
- Erland Strömbäck, *Personal Injury Compensation in Sweden*, 2000,
- Claus Granath, "Jury fäller Sjöberg för förtal", 2006,
- Judith Platania Garrett L. Berman, *The Moderating Effect of Judge's Instructions on Victim Impact Testimony in Capital Cases*,
- John P. Wilson, *PTSD and Complex PTSD Symptoms, Syndromes, and Diagnoses*.